



"УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР" ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 03 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар 04


Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн Тухай Хуулийн 59, 60, 62, 64, 65, 71-р зүйл, 76-р зүйлийн 76.1.2 заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны Пүрэв гарагт 10.00 цагт Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Мишээл экспогийн хойд талд ИБИС Стайлс Улаанбаатар зочид буудлын 6 давхрын Поларис хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах,
 2. Компанийн 2019 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан тэнцэл, түүнд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг хэлэлцэж батлах,
 3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны зардлын төсвийг батлах,
 4. Компанийн дүрмийн өөрчлөлтийг батлах,
 5. Компанийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөх төслийг батлах,
 6. Компанийн эд хөрөнгийн үнэлгээг дахин хийлгэх зөвшөөрлийг олгох,
 7. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох.
3. Компани нь сүүлийн жилүүдэд бий болсон хуримтлагдсан алдагдлаа нөхөж чадаагүй тул 2019 оны тайлант жилийн үйл ажиллагааны орлогоос ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэснийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулсугай.
4. Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан 2020 оны 03 дугаар сарын 19-ны өдөр хурлын зарыг нийтэд эхэлж хүргэхээр тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг 2020 оны 03 дугаар сарын 19-ны өдөр, 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрүүдэд Засгийн газрын мэдээ, Өнөөдөр гэсэн өдөр тутмын сонинууд, TV9, UBS телевизүүдээр хувьцаа эзэмшигчдэд хүргэхээр тогтоосугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөр тасалбар болгосугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг "Хавсралт 1"-ээр баталсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх хурлын материал, санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлт болон бусад бичиг баримт, шийдвэрийн төсөлтэй хувьцаа эзэмшигчид ХУД-ийн 2-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 67/1 хаягт буюу Номин Юнайтед цогцолборын 5-р давхарт ТУЗ-ийн нарийн бичгийн дарга дээр Даваа-Баасан гаригуудад ажлын цагаар танилцах боломжтой болохыг мэдээлсүгэй.
9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудсыг "Хавсралт 2"-оор баталсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалыг Брокер дилерийн компаниудаар дамжуулан тараахыг зөвшөөрсүгэй.
11. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах сүүлчийн хугацааг 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөр тасалбар болгож, брокер дилерийн компани болон ХУД-ийн 2-р хороо Чингисийн өргөн чөлөө, 67/1 хаягт буюу Номин Юнайтед цогцолборын 5-р давхарт тус тус хүлээж авахаар тогтоосугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Гүйцэтгэх захирал С.Сайнбатыг томилсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын даргаар тооцооны нягтлан бодогч Ж.Пүрэвжаргал, өмгөөлөгч Н.Цагаанхүү, өмгөөлөгч Э.Батбаяр томилсугай.
14. Хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирал С.Сайнбатыг, гишүүдээр Төлөөлөн удирдан зөвлөлийн дарга В.Хүрэлхад, тахлах нягтлан бодогч Д.Чимгээ нарыг томилж, хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган ажиллахыг үүрэг болгосугай.

ДАРГА



С.ХОСБАЯР